

ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГААНД КИНЕТИК ЦОХИЛТЫН (РЕЗИНЭН БА ХУВАНЦАР) СУМЫГ НЭВТРҮҮЛЭХ, АШИГЛАХ

25 ДҮРЭМ

ХУРААНГУЙ

ТОДОРХОЙЛОЛТ

Дэлхий дахинаа хууль сахиулах ажиллагааны өөр өөр зорилгоор зохион бүтээгдсэн олон төрлийн тусгай хэрэгсэл, зэвсгийг хууль сахиулах байгууллагын алба хаагчид ашиглаж байна. Резинэн ба хуванцар сумыг хувийн гэрээт харуул, хамгаалалтынхан, хууль сахиулах байгууллагын алба хаагчид хэрэглэдэг бөгөөд хүний амь насанд аюул багатай нэг бүрийн тусгай хэрэгслийн төрөл юм.

Резинэн ба хуванцар сумыг ашиглахдаа хуульд заасан үндэслэл журмын дагуу тулгарсан довтолгоо, аюулын эсрэг тухайн нөхцөл байдалд тохирсон байх; аль болох бага хор хөнөөл учруулах; ялгаварлахгүй байх; учруулсан үр дагаварыг арилгах зэрэг хууль сахиулах ажиллагаанд албадлага, нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэхэд баримтлах тодорхой зарчмыг хэрэгжүүлэх нь чухал.

Хууль ёсны байх

Албадлага, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх, тэр дундаа резинэн ба хуванцар сум зэрэг амь насанд аюул багатай нэг бүрийн тусгай хэрэгслийн хэрэглээг олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцсэн үндэсний хууль тогтоомжоор бүрэн зохицуулах ёстой. Хууль сахиулах байгууллагын алба хаагчид олон улсын хүний эрхийн хууль болон хэм хэмжээнд нийцүүлж зөвхөн хуульд заасан үндэслэл журмын дагуу зүй ёсны зорилгоор албадлага, хамгаалалт хэрэглэж болно. Албадлага, хамгаалалтыг хуульд заасан үндэслэл журмаас гадуур бусдыг айлган сүрдүүлэх, шийтгэх зорилгоор хэрэглэхийг олон улсын хүний эрхийн хуулиар хориглодог.

Зайлшгүй байх

Хууль сахиулах байгууллагын алба хаагчид хууль ёсны зорилгод хүрэхдээ тухайн үйлдэл эс үйлдэхгүйг зогсоох аргуудаас хамгийн хор хөнөөл багатай арга хэрэгслээс сонгон хэрэглэнэ. Хууль ёсны зорилго, хуульд заасан үйл ажиллагаа хэрэгжиж дуусмагц хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэхийг хурдан хугацаанд зогсооно.

Тохирсон байх

Хууль сахиулах байгууллагын алба хаагч нь хуульд заасны дагуу хууль бус үйлдлийг таслан зогсоох, албадлага, хүч хэрэглэх эрхтэй бөгөөд урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн нөхцөл байдлаас хэтрүүлсэн хүч хэрэглэх ёсгүй.

Бусдад хууль бусаар халдан довтолсон, аюул учруулсан үйлдлээс хохирол, хор уршиг учирч болзошгүй үндэслэл бүхий нөхцөл үүссэн бол тухайн үйлдлийг таслан зогсоох хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэсэн бол хууль ёсны гэж үзнэ. Хэрэв өөр арга хэрэгслээр аюулыг зайлуулж болохоор байхад нөхцөл байдлаас нь хэтрүүлсэн хүч, албадлага хэрэглэсэн бол тохирсон хүч хэрэглэсэн гэж үзэхгүй.

Ялгаварлахгүй байх

Үндэсний цөөнх, эмэгтэйчүүд, ЛГБТИК+ хүмүүс зэрэг тодорхой бүлэгт чиглэж ялгаварлан гадуурхсан байдлаар хэзээ ч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болохгүй.

Хариуцлага тооцох

Хууль сахиулах байгууллагын алба хаагчид, түүнчлэн удирдах албан тушаалтнууд хүч хэрэглэсэн тохиолдол бүртээ хариуцлага хүлээнэ.

Резинэн ба хуванцар сум нь “галт зэвсэг”-ээс ялгаатай бөгөөд хүний бие махбодид учруулах гэмтэл, хор уршиг нь бага, амь насанд шууд аюул учруулахааргүй (хөнгөн гэмтэл учруулах) байна. Тухайлбал, энэ зэвсэг нь нэг бүрийн тусгай хэрэгсэл болох хийн бууны хийг энерги болгон хувиргаснаараа гэмтэл учруулж, биеийн өнгөн хэсэгт хохирол учруулж, довтолгооныг няцаах зориулалттай байдаг.

Гэсэн хэдий ч резинэн ба хуванцар сум нь тодорхой тохиолдолд ойрын зайнаас хүний амь насанд аюул учруулах боломжтой тул аюултай нэг бүрийн тусгай хэрэгсэл юм. Гарцаагүй үед тухайн нөхцөл байдалд тохируулан дээрх нэг бүрийн тусгай хэрэгслийг сонгон хэрэглэнэ.

РЕЗИНЭН БА ХУВАНЦАР СУМЫГ НЭВТРҮҮЛЭХ, АШИГЛАХАД БАРИМТЛАХ ДҮРЭМ ЖУРАМ, ҮНДСЭН ЗАРЧИМ

РЕЗИНЭН БА ХУВАНЦАР СУМЫГ НЭВТРҮҮЛЭХ, АШИГЛАХ ЕРӨНХИЙ ДҮРЭМ

1. Резинэн ба хуванцар сумны учруулж болзошгүй эрсдлийг харгалзан үзэж хүчний хэрэглээний дээд түвшинд, галт зэвсгийн (үхлийн аюултай зэвсэг) доод түвшинд эрэмбэлнэ. Тиймээс хууль сахиулах байгууллагууд энэ төрлийн зэвсгээс үүдэлтэй ноцтой эрсдлийг зөвтгөж болох онцгой нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэхдээ зайлшгүй ашиглах шаардлагатай байгаагаа тодорхой болгохоос нааш алба хаагдаа резинэн ба хуванцар сумаар хангах ёсгүй.
2. Резинэн ба хуванцар сум нь нийтийн хэв журам сахиулах стандарт хэрэгсэл биш бөгөөд жагсаал, цуглааныг тараах хэрэгслээр ашиглагдах ёсгүй.
3. Резинэн ба хуванцар сумыг зөвхөн хувь хүний үйлдэж буй хүчирхийллийн эсрэг, тухайлбал, ноцтой хүчирхийлэл үйлдэж, бусад хүмүүст ихээхэн хохирол учруулах эрсдэлтэй хүний аюулыг таслан зогсоох хор хөнөөл багатай өөр арга байхгүй үед л хэрэглэнэ. Тухайн хүний хүчирхийллийн шинжтэй зан байдлыг таслан зогсоох зорилгоор л ашиглана.
4. Резинэн ба хуванцар сумыг хүмүүс бужигнан гүйлдэж буй хэт үймээнтэй нөхцөлд ашиглахгүй. Учир нь энэ тохиолдолд хүчирхийлэл үйлдэж буй хүнийг тодорхой онилох боломжгүй байдаг. Нийгмийн хэв журмыг сахиулах ажиллагааг удирдаж буй албан тушаалтан энэ төрлийн зэвсэг ашиглах нөхцөл байдлыг, эсвэл гэмгүй хүнийг онилох эрсдэл хэт их байгаа эсэхийг үнэлэх онцгой үүрэгтэй.
5. Резинэн ба хуванцар сумыг тайван замаар, хүчирхийллийн шинжгүй эсэргүүцэж буй хүмүүс эсвэл зугтаж байгаа хүний эсрэг хэзээ ч хэрэглэж болохгүй.
6. Резинэн ба хуванцар сум хэрэглэсэн тохиолдол бүр нь хууль ёсны, зайлшгүй, тохирсон байх зарчмын дагуу үндэслэлтэй байх ёстой (мөн холбогдох хууль сахиулах албан тушаалтан хариуцлага хүлээнэ). Тиймээс буудах тохиолдол бүрийн өмнө нөхцөл байдлыг зохих ёсоор үнэлэх бөгөөд резинэн ба хуванцар сумыг хяналтгүйгээр давтан хэрэглэхгүй.
7. Нийтийн хэв журам сахиулахдаа хууль сахиулах байгууллагын зөвхөн тусгайлан бэлтгэгдсэн алба хаагчид резинэн ба хуванцар сумыг гарцаагүй хэрэглэх онцгой нөхцөлд холбогдох дээд удирдлагын хяналтан доор хэрэглэнэ.

АНХААРУУЛГА

8. Дүрмээр бол резинэн ба хуванцар сумыг залуучууд, эсвэл бага насны хүүхэд эсвэл бие жижигтэй, илүү ноцтой гэмтэх биеийн нимгэн хэсэг нь өртөх магадлал өндөртэй бусад хүмүүст хэрэглэж болохгүй.
9. Цаашилбал, хууль хяналтын байгууллага хүүхэд залуучууд олноор цугларсан, тухайлбал, оюутнуудын жагсаал, эсвэл залуучуудын зохион байгуулсан, оролцсон жагсаалын үеэр нийгмийн хэв журам сахиулахдаа резинэн ба хуванцар сумыг хэрэглэхээс татгалзах ёстой.

ХЭРЭГЛЭХ АРГА ЗАМ

10. Резинэн ба хуванцар сумтай бууг ашиглахаас өмнө жагсагч нарт дэг журам баримтлах, хүчирхийллийн шинж бүхий зан байдлаа зогсоохыг тодорхой анхааруулж, тэдэнд хангалттай хугацаа өгөх ёстой.
11. Резинэн ба хуванцар сумаар хэзээ ч бөөгнөрсөн, хурсан олны зүг буудаж болохгүй.
12. Хүний биед хүнд гэмтэл учруулахгүйн тулд зэвсэг биеийнх нь доод хэсэг рүү чиглэнэ, ялангуяа толгой, нүүр эсвэл нүд рүү гээд биеийн дээд хэсэг рүү огт онилж болохгүй.
13. Сумны чиглэлийг оновчгүй болгож, хүнд гэмтэл учруулах эрсдэлийг ихээхэн нэмэгдүүлдэг учир тухайн зэвсгийг газар руу чиглүүлж, газарт ойлгож хий буудаж болохгүй.
14. Резинэн ба хуванцар сумтай бууг үйлдвэрлэгчийн зааварласан тохиромжтой зайнаас, хууль сахиулах байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр буудах ёстой.
15. Хүний толгойг онох эрсдэл ихтэй тул өндөр байрлалаас (жишээ нь дээврийн орой дээрээс эсвэл дроноор) резинэн ба хуванцар сумаар хэзээ ч буудаж болохгүй.

16. Резинэн ба хуванцар сумны улмаас гэмтэж бэртсэн хүний гэмтлийг ноцтой гэмтэл гэж үзэн гэмтсэн хүн зохих, яаралтай эмнэлгийн тусламж авах боломжтой байх ёстой.

ХОРИГЛОХ ЗЭВСЭГ

17. Резинэн бөмбөг, хэт хүчтэй цохилттой резинэн бүрээстэй метал сум бүхий олон сумтай, хэт их хохирол, гэмтэл учруулах эрсдэлтэй бүх загварын резинэн ба хуванцар сумыг хориглох ёстой.

ЗААВАРЧИЛГАА БА СУРГАЛТ

18. Хууль сахиулах байгууллагууд бие бүрэлдэхүүндээ резинэн ба хуванцар сум ашиглах, тэр дундаа тусгайлан хэзээ, хэрхэн ашиглах талаар нарийн тодорхойлсон нөхцөл байдал, хор хөнөөлийг багасгах урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тэдгээрийг хэзээ хэрхэн ашиглахгүй байхыг тодорхой заах ёстой. Эдгээр зэвсгийг зөвхөн сургалтад сууж гэрчилгээ авсан хууль сахиулагч нарт олгоно.

ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТ

19. Тухайн зэвсгийг хууль ёсны болоод зохистой байдлаар хэрэглэх зарчмыг мөрдөөгүй хууль сахиулах байгууллагын алба хаагч, удирдах албан тушаалтанд сахилгын болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх замаар холбогдох дүрэм, журам, хүний эрхийн хэм хэмжээг зөрчсөн резинэн ба хуванцар сум ашиглах тохиолдол бүрд зохих хариу арга хэмжээ авах ёстой.

20. Хууль сахиулах байгууллага резинэн ба хуванцар сумаар буудсан хууль сахиулах байгууллагын алба хаагчийг тогтоохын тулд ийм төрлийн зэвсгээр тоноглогдсон зөвхөн цөөн тооны алба хаагчийг ажиллуулах, мөшгөх боломжтой сум ашиглах болон тодорхой удирдлага, чиглэлээр хангах зэргээр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.
21. Хууль сахиулах байгууллага нь резинэн ба хуванцар сум ашиглахтай холбоотой ерөнхий нөхцөл байдалд байнга үнэлэлт дүгнэлт өгч, ашигласан сум, харвах төхөөрөмж, үүнтэй холбоотой тогтоосон бодлого, заавар, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын сургалт, захирагч нарын үүрэг зэрэгтэй холбоотой алдаа дутагдлыг нэн даруй арилгана. Холбогдох бүх бодлого олон нийтэд ил, хүртээмжтэй байх ёстой.
22. Хэрэв хууль сахиулах байгууллагын удирдлага зохих арга хэмжээний дагуу резинэн ба хуванцар сумны хэт их хохирол, гэмтлийг зогсоож, урьдчилан сэргийлж чадаагүй бол өөрсдийнх нь захиргааны, сахилгын арга хэмжээ болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

ТУРШИЛТ, ХУДАЛДАА, ЗӨӨВӨРЛӨЛТ

23. Хууль сахиулах байгууллагын алба хаагчийн хэрэглэж буй бүх зэвсэг, тэр дундаа резинэн ба хуванцар сум, харвагчийг ашиглахад аюулгүй, тохиромжтой эсэхийг нь хүний эрхийн шалгуурт нийцүүлэн, хөндлөнгийн туршилтад хамруулан сайтар шалгах ёстой. Нэн ялангуяа, резинэн ба хуванцар сумтай буугаар галлах зай нь хөхрөлт үүсгэхээс илүү нөлөө үзүүлэхгүйгээр хангалттай нарийвчлалтай байгаа эсэхийг нягтлах нь чухал.

24. Тусгай хэрэгсэл нь хүний эрхийн ноцтой зөрчилд ашиглагдаж байгаа гэх үндэслэл буй бол улс орнууд резинэн ба хуванцар сум, түүнийг харвагч тусгай хэрэгслүүдийг экспортлохыг зөвшөөрөх ёсгүй.
25. Резинэн ба хуванцар сум болон холбогдох харвагчийн загвар нь хэт их гэмтэл, аюул учруулж болзошгүй тухайлбал олноор галладаг сумтай, резинэн бүрээстэй металл сумтай бол үйлдвэрлэж, худалдаалахыг хориглоно.

ХИЙЖ БОЛОХ БА БОЛОХГҮЙ ҮЙЛДЭЛ:

ХИЙЖ БОЛОХ: Хууль сахиулах алба хаагчид дараахь зүйлсийг **мөрдөнө**:

- ✓ Хэн нэгэн бусдад ноцтой хохирол учруулж болзошгүй байгаа нөхцөлд л зөвхөн хүчирхийллийг зогсоох зорилгоор резинэн ба хуванцар сум хэрэгслийг ашиглах.
- ✓ Хор хөнөөл багатай өөр арга байхгүй тохиолдолд л эцсийн арга болгон резинэн ба хуванцар сум хэрэгслийг ашиглах.
- ✓ Резинэн ба хуванцар сум хэрэгслийг ашиглах гэж байгаа бол нөлөөлөлд өртөх хүмүүст анхааруулга өгч, тэдэнд тушаал биелүүлэх хангалттай хугацаа өгсөн байх.
- ✓ Тухайн хэрэгслийг ашиглахдаа эмзэг бус хэсгүүд (биеийн доод хэсэг, үе мөчөөс бусад хэсэг) рүү онилох, биеийн дээд хэсэг, толгой, цавь хэсгийг онилохгүй байх.

Резинэн ба хуванцар сумыг хэрэглэсэн тохиолдол бүр үндэслэлтэй байх.

ХИЙЖ БОЛОХГҮЙ: Хууль сахиулах алба хаагчид дараах үйлдлийг **огт хийж болохгүй**:

- ✗ Резинэн ба хуванцар сум хэрэгслийг тайван замаар, хүчирхийллийн шинжгүй эсэргүүцэж буй эсвэл зугтаж байгаа хүний эсрэг хэрэглэх.
- ✗ Резинэн ба хуванцар сум, хэрэгслийг жагсаал, цуглааныг тараах хэрэгсэл болгон ашиглах.
- ✗ Хурсан, бөөгнөрсөн олон руу резинэн ба хуванцар сумаар буудах.
- ✗ Биеийн дээд хэсэг рүү онилох.
- ✗ Олон сум ашиглах.